



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

СТАНДАРТ, ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ч.ПҮРЭВДОРЖ ТАНАА

2022. 10. 26 № 7/2456
танай _____-ны № _____-т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 9 дүгээр сарын 22-д тус байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Тухайн байгууллагад холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэлжүүлж хяналтад аваагүй.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хяналтад аваагүйн улмаас дээд газраас ирүүлсэн тайлангийн маягтын дагуу тухайн үед нь гаргаж явуулдаг, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгасан заалт байхгүй байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэх арга хэмжээний хариуцах эзэн буруу тодорхойлсон. (аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар г.м)

Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн зарим шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин буруу байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцах эзэн тодорхойлоогүй учир мэргэжилтэнүүд хариуцсан зарим ажлаа төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй.

2 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд олон заалтын хүрэх түвшин тодорхойлоогүй орхигдуулсан.

Нийт мэргэжилтнүүд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс өөрийн хариуцсан ажлыг албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгахдаа шууд хуулж тавьсан байна.

5 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй тулган шалгахад 2 албан хаагч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ жилийн төлөвлөгөөнд тусгаагүй албан тушаалын тодорхойлолтоо хянаагүй байна.

2.

Байгууллагын үйлчилгээний стандартын дагуу бүгд энгэрийн тэмдэг ажлын хувцастай байсан боловч өрөө тасалгааны эмх цэгц, цагийн бүртгэл хангалтгүй байна. Албан хаагчдын хувийн хэргийн бүрдлээс хадам аав ээжийн намтар, төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалтын дүн зэрэг нь дутуу байна.

Зөвлөмж:

1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн холбогдох заалтуудыг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 10.7-д заасны дагуу хяналтад авч, жил бүр жагсаалтыг шинэчлэн байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах

2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцах эзэнг тодорхой зааж, холбогдох мэргэжилтнүүд тухайн заалтыг өөрийн төлөвлөгөөнд задалж оруулах

3.Шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлж, хүрэх түвшин суурь түвшинтэй уялдуулах

4.Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг дахин хянаж өөрийн албан тушаалын тодорхойлолт, ажлын чиг үүрэгтэй уялдуулан орхигдсон заалтуудыг нэмж оруулах

5.Ажлын байрандаа эмх цэгцтэй зөвхөн ажилд ашиглах зүйлсээ ойр байлгаж, илүүц зүйлсийг цэгцлэх

6.Байгууллагын үйлчилгээний стандартыг чанд мөрдөх

7.Засгийн газрын 100 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Хувийг: Стандарт, хэмжилзүйн газарт

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ГАНЧИМЭГ

